



ДУНГОВЬ АЙМАГ  
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/14

Решение

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх сумын "Авлигын эсрэг 2017 оны төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

Хоёр. Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан хэрэгжүүлж, "Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал"-ын дагуу тайлан мэдээг гаргаж үнэлүүлэхийг сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Хорлоо/-д үүрэг болгосугай.

Гурав. Төлөвлөгөөний холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тусгайлан төсөв батлуулан зарцуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, байнгын хяналт тавьж, тайланг /нотлох баримт, бусад материалын хамт/ 11 дүгээр сарын 01-ний дотор Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, зүйн хэлтэст хүргүүлж тайлагнахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг ханган Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Хорлоо/, төсөв шууд захирагч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

И.ЭРДЭНЭБИЛЭГ



Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2017 оны 02 сарын 02 ны өдрийн 10001/2017-02/02 тоот захирамжийн хавсралт



**ӨЛЗИЙТ СУМЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

❖ **Зорилго:** Шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн авлига, хүнд сурталаас ангид, хариуцлагатай төрийн албыг бүрдүүлэх.

**Зорилт 1.** Авлига, хүнд суртлаас урьдчилан сэргийлж, төрийн албан хаагчдын шударга байдал, ёс зүйтэй манлайллыг нэмэгдүүлнэ.

**Зорилт 2.** Авлига, ашиг сонирхлын зөрчил, хүний эрх, төсвийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлнэ.

**Зорилт 3.** Төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлыг сайжруулна.

**Зорилт 4.** Түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлж, Авлигатай тэмцэх санал санаачилгыг нэмэгдүүлнэ

**Зорилт 5.** Гарч буй бодлого шийдвэрт иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ


**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ХУГАЦАА	ХАРИУЦАГЧ БАЙГУУЛЛАГА, АЖИЛТАН	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР	ОНОО 0-5
<b>Зорилт 1.</b> Авлига, хүнд суртлаас урьдчилан сэргийлж, төрийн албан хаагчдын шударга байдал, ёс зүйтэй манлайллыг нэмэгдүүлнэ.					
1.1	Төрийн албан хаагчдын шударга байдал, ёс зүйтэй манлайллыг нэмэгдүүлэх хүрээнд Төрийн Жинхэнэ албан хаагчдын Тангараг сэргээх ажлыг шинээр зохион байгуулна	1 сард	Б. Хорлоо	Сонгуулийн жил болж байгаатай холбогдуулан Төрийн албан хаагчдын шударга байдал, ёс зүйн зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлнэ	
1.2	Уламжлалт Төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг зохион байгуулна.	жилдээ	Төсөв шууд захирагч нар	Албан хаагчид Төрийн албаны мөн чанарыг эрхэмлэх ойлголт сайжирна.	

1.3	Төрийн үйлчилгээний бүх байгууллагуудад Сумын ёс зүйн хорооноос зөвлөн туслах, ажил зохион байгуулна.	2 –р улиралд	Сумын ёс зүйн хороо	Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээ сайжирна.	
1.4	Иргэдээс санал асуулгаар уламжлалт Ёс зүйтэй манлайлагч Албан хаагчийг шалгаруулж Алдаршуулна.	11 сард	Төсөв шууд захирагч нар		
1.5	Авлигын эсрэг сургалтуудыг зохион байгуулна	Улирал бүр	Эрх зүйн хөтөч баг	Иргэд авлигийн тухай ойлголт авна.	
<b>Зорилт 2.</b> Авлига, ашиг сонирхлын зөрчил, хүний эрх, төсвийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлнэ. .					
2.1	Төрийн албан хаагчдыгнэрсээр санал асуулга авах ил тод мэдээлэх	4 –р улиралд	Б. Хорлоо	Авлигаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.	
2.2	Ашиг сонирхлын зөрчил, үүсэх, үүссэн тухай мэдэгдэл тайлбар гаргуулах, Иргэдэд ойлголт өгөх сургалт явуулах	Тухай бүр	Б. Хорлоо	Авлигаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.	
2.3	Хүний эрх, ИНБ-ын хамтарсан сургалт Төрийн албан хаагчид, иргэдийн дунд явуулах	жилд	Эрх зүйн хөтөч баг	Иргэдийн ойлголт нэмэгдэнэ.	
2.4	Төсвийн тухай ойлголт , ил тод байдлын тухай сургалт иргэдэд зохион байгуулах	3-р улиралд	Санхүүгийн алба Б. Болдбаатар	Иргэдийн ойлголт нэмэгдэнэ	
2.5	Шилэн дансны мэдээлэлээр сургалт явуулах	2-р улиралд	Санхүүгийн алба Б. Болдбаатар	Иргэдийн ойлголт нэмэгдэнэ	
<b>Зорилт 3.</b> Төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлыг сайжруулна.					
3.1	Байгууллага бүр Засгийн газрын 143-р тогтоолын дагуу төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллана.	жилдээ	Төсөв шууд захирагч нар	Байгууллагын үйл ажиллагаагы ил тод байдал хангагдана	
3.2	ТББайгууллагуудаар иргэдийн үнэлгээ хийлгэж Сумын мэдээллийн самбарт байршуулж ил тод танилцуулна.	4-р улиралд	Ахмадын зөвлөл	Иргэдийн оролцоо хангагдана. Үйл ажиллагаа сайжирна.	

<b>Зорилт 4. Түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлж, Авлигатай тэмцэх санал санаачилгыг нэмэгдүүлнэ</b>				
4.1	ТББайгуулагуудтай хамтарч ажиллана Үүнд : Төсөвт байгууллага бүр нэг ТББ-ийг хамтарч нэг бүтээлч ажил зохион байгуулна.	жилд	Төсөв шууд захирагч нар	Хамтын ажиллагаа өргөжинө.
<b>Зорилт 5. Гарч буй бодлого шийдвэрт иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ</b>				
5.1	Багийн нэгдсэн өдөрлөг, ОНХСангийн санал асуулга тогтмолжуулах	Жилд	Төсөв шууд захирагч нар	Хамтын ажиллагаа өргөжинө.

Төлөвлөгөө болж өргөсүүлсэн :

ЗДТГ-ЫН ДАРГА  Б. ХОРЛОО

